



ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
ЭХИЙН ЭЛБЭРЭЛ-ДАМБА САН
АШУУИС

"ЭМИЙН ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТЭД ХИЙСЭН СУДАЛГАА"

Судлаач:

М.Алтанцэцэг ЭЗУ-ны магистр, ЭЭХХЗГ-ын ЭББХУБ
Ч.Энхсаруул Сүхбаатар-Эм холбооны тэргүүн,
Энэрэлт баясгалан ХХК
Г.Мөнхцацрал ЭЗУ-ын магистр, Сүхбаатар Монос ХХК

СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, хүн амын эрүүл мэндийг хамгаалах нэгдсэн бодлого, үйл хэрэг үзэл баримтлалын салшгүй хэсэг бол эм зүйн салбар бөгөөд эмийн чанар, аюулгүй байдал нь өнөөгийн нийгмийн тулгамдаад байгаа асуудлуудын нэг болоод байна.

Иймд Сүхбаатар аймгийн эм зүйн тусламж үйлчилгээний чиглэлээр эмийн зохистой хэрэглээг судалж эмийн зохистой хэрэглээний өнөөгийн нөхцөл шалтгааныг тогтоох, практик дээр эмийг хэрхэн зөв зохистой хэрэглэж байгааг нотлох шаардлагатай байгаа нь энэхүү сэдвийг сонгож авах үндэслэл болсон.

СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ



Зорилго

Сүхбаатар аймгийн Эрүүл мэнд болон эм хангамжийн байгууллага, иргэдийн эмийн зохистой хэрэглээний талаарх мэдлэг, дадал, хандлагыг судалж, нөлөөлж буй шалтгааныг тогтоох.



Зорилт 1

Эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж буй их бага эмч нарын эмийн сонголт хийхэд нөлөөж буй хүчин зүйлс, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгч эмийн зохистой хэрэглээний талаар мэдлэг хандлагыг тодруулах.

Зорилт 2

Эмийн сангаар үйлчлүүлэгч иргэдийн эмийн зохистой хэрэглээний талаарх мэдлэг, дадал, хандлагыг үнэлэх, эмийн сангийн үйлчилгээ нөлөөлж буй хүчин зүйлсийг тогтоох.

Зорилт 3

Эмийн сангийн иргэдээс хүлээн авсан жорын маягтын MNS5376:2016 стандартын мөрдөлтөд дүн шинжилгээ хийх.

Зорилт 4

Эмийн зохистой хэрэглээний зарим үзүүлэлтэд хийсэн судалгааны дүнд үндэслэн зөвлөмж, асуумж боловсруулах.



СУДАЛГААНЫ АЖЛЫН ШИНЭЛЭГ ТАЛ

Эмийн зохистой хэрэглээний гол бүрэлдэхүүн хэсэг болох 3 сегмент (иргэд, эмч, эмийн мэргэжилтэн)-ээс судалгаанд хамруулан эмийн зохистой хэрэглээний зарим үзүүлэлтүүдийг Сүхбаатар аймгийн эм хангамжийн байгууллага болон эрүүл мэндийн байгууллагуудаас авсан цахим болон баримт бичгийн асуумж хууль ёсны баримтад үнэлэлт дүгнэлт хийж, хэрэгжилт сул болон хэрэгжихгүй байгаа асуумж, баримт бичгийг түүвэрлэн гаргаж, тэдгээрийн шалтгааныг тодруулж, цаашид сайжруулах зөвлөмж боловсруулж байгаа нь уг судалгааны ажлын шинэлэг тал болно.

СУДАЛГААНЫ ПРАКТИК АЧ ХОЛБОГДОЛ:

Нийтийн үйлчилгээтэй эмийн санд хүлээн авсан жорд судалгаа хийж, эмч, стационарт хэвтэн эмчлүүлэгчийн эмийн зохистой хэрэглээ, эмийн жор бичилт, эм олголтын өнөөгийн бодит байдал цаашид эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд эмч, эмийн мэргэжилтэн, иргэдийн зүгээс анхаарах, сайжруулах асуудлыг бодитой гаргаж байгаа нь эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, салбарын тулгамдсан асуудалд зохих дүгнэлт хийх нь практикийн ач холбогдолтой юм.

СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН, АРГА ЗҮЙ

СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН:

“Эмчийн эмийн сонголт, зохистой хэрэглээний талаарх асуумж хуудас” 24 асуулттай асуумж хуудас

“Хэвтэн эмчлүүлэгчдийн эмийн эмчилгээний талаарх асуумж хуудас” 17 асуулттай асуумж хуудас

Сүхбаатар аймгийн нийтийн үйлчилгээтэй 8 эмийн сангийн 2023 оны 09–12-р сар, 2024 онд иргэдээс хүлээн авсан АНЭ-ийн 44 эмч, Энхлэн, Энэрэлт ачтан ӨЭМТ-ийн 17 их бага эмч нарын бичсэн 3058 эмийн жорын маягт.

“Үйлчлүүлэгчийн эмийн зохистой хэрэглээ, антибиотикийн талаарх мэдлэг хандлага, эмийн сангийн үйлчилгээ” 14 асуулттай асуумж хуудас.

СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН, АРГА ЗҮЙ

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ:

1. Нэг агшингийн загвар, баримт судалгааны аргаар урьдчилан боловсруулсан асуумж хуудсыг ашиглан гүйцэтгэсэн.
2. Харьцуулан дүгнэх болон нэгтгэн дүгнэх /контент анализ/ аргыг хослуулан гүйцэтгэсэн.

Үнэлгээ:

❖ Эмч, стационарт хэвтэн эмчлүүлэгчийн эмийн зохистой хэрэглээ:

- ✓ 0-50 хувь хангалтгүй
- ✓ 60-100 хувь хангалттай

❖ Эмийн жор бичилт:

- ✓ 0-120 бага
- ✓ 130-240 дунд
- ✓ 250-360 их



❖ Иргэдийн эмийн зохистой хэрэглээ, эмийн сангийн үйлчилгээ:

- ✓ Хангалттай
- ✓ Хангалтгүй


Үр дүнгийн статистик боловсруулалт:

Судалгааны ажлын үр дүнг Microsoft Excel, статистик боловсруулалтын SPSS 2200 программыг ашиглан боловсруулах боломжтой.


СУДАЛГААНД ХАМРАГДСАН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА БОЛОН ЭМЧ, СТАЦИОНАРТ ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭГСЭД



СУДАЛГААНД ХАМРАГДСАН ЭМИЙН САНГААР ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АНТИБИОТИКИЙН ТАЛААРХ МЭДЛЭГ СОРИХ СУДАЛГААД ХАМРАГДСАН ИРГЭД



СУДАЛГААНД ХАМРАГДСАН ЭМИЙН САН БОЛОН БАРИМТ БИЧИГ




ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОН ЭМ ХАНГАМЖИЙН БАЙГУУЛЛАГА, ИРГЭДИЙН ЭМИЙН ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТЭД ХИЙСЭН СУДАЛГААНЫ БАРИМТ БИЧИГ БОЛОН АСУУМЖ СУДАЛГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Эмийн зохистой хэрэглээний чиглэлээр 2023-2024 онуудад судалгаанд хамрагдсан байгууллагуудыг бүтэц үйл ажиллагааны чиглэлээр нь:

- Нэгдсэн эмнэлэг,
- Нийтийн үйлчилгээтэй 1, 2 дугаар зэрэглэлийн эмийн сан,
- Сум, тосгоны эрүүл мэндийн төв,
- Өрхийн эрүүл мэндийн төв,
- Клиникийн хэвтүүлэн эмчлэх эмнэлэг гэсэн 5 төрөлд хувааж, судалгааны асуумжид тусгагдсан агууллагууд эрүүл мэндийн байгууллагуудад мөрдөгдөж буй 5 хууль, 2 тогтоол, 16 тушаал, 5 стандартад тусгагдсан болно.

1. СУДАГААНД ХАМРАГДСАН 91 ИХ БАГА ЭМЧИЙН ЭМИЙН ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭНИЙМЭДЛЭГ, ДАДАЛ, ХАНДЛАГЫГ ТОДРУУЛЖ СУДЛАСАН ДҮН



Эмийн зохистой хэрэглээний талаарх зөвлөгөөг 86%(78) өгч хэвшсэн, жорын маягтаар 91.20%(83) нь тасралтгүй хангагддаг, антибиотик эмчилгээг (87) 96% нь 5-7 хонгийн хугацаанд зааж байна.

ЭМЧИЙН ЭМИЙН СОНГОЛТ ХИЙХЭД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛ

Д/д	Ерөнхий мэдээлэл	Үзүүлэлт	Хувь
1	Эмийн зохистой хэрэглээний талаархи мэдээлэл	Эмч нарийн амбулаториор үйлчлүүлсэн иргэдэд зөвлөсөн эмийн эргэн хяналт, эмчилгээний удирдамж хангалттай байдаггүй, эмийн талаарх мэдлэг мэдээлэл дутмаг, стационар болон амбулаториор үйлчлүүлж буй иргэдийн эмийн зохистой хэрэглээний мэдлэг дутмаг, эмч нарын бактериологи болон бусад шаардлагатай шинжилгээг хурдан хугацаанд хийх боломж хомс.	40%(65)
2		Эмчилгээний удирдамж.	52.70(48)
3	Эмч нарын хамрагдахийг хүсж буй сургалт	Шинэ эмийн мэдээлэл.	64.80%(59)
4		Эмийн зохистой хэрэглээ.	46.20%(42)
5		Эмийн сонголт, харилцан нөлөөлөл.	59.30%(54)

СТАЦИОНАРТ ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭГЧ 224 ИРГЭНД ҮЗҮҮЛЖ БУЙ ЭМИЙН ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭГ ТҮҮВЭРЛЭЖ СУДАЛСАН ДҮН




СТАЦИОНАРТ ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭГЧИД ҮЗҮҮЛЖ БУЙ ЭМИЙН ЗОХИСГҮЙ ХЭРЭГЛЭЭГ ТОДРУУЛЖ СУДАЛСАН ДҮН

Д/д	Үзүүлэлт	Хувь
1	Тариаг нэг зүүгээр дараалуулж тарьсан тохиолдол.	52.2%
2	Хольж тарьсан тариа нийт хэвтэн эмчлүүлэгч.	37.1%
3	Эмийг цаг хугацаанд нь олгоогүй.	34%
4	Стационарт хэвтэн эмчлүүлэгчдээр эм, тариа авч ирүүлсэн.	12.2%
5	Хувиас нь авч ирүүлэн эм, тарианы мөнгөн дүнг буцаан авах талаар мэдээлэл өлгөөгүй.	36%
6	Эмчилгээнд сонгосон эм, тариа, дусал, тан эмийн хэлбэрийн нэр төрлийг тогтоох	4 эм сонгосон тохиолдол 33.20%-д нь, 5-с дээш эм сонгосон нь тохиолдол 3.10% (18.15% дундаж) 4-н тариа, дуслыг 16.40%-д, 5-н тариа, дуслыг 9.40%-д, 5-с дээш дуслыг 4.01% (29.81% дундаж) 4-танг 19.30%-д, 5-н танг 67.70%-д, 5-с дээш танг 1.30% (29.43% дундаж)

2. ЭМИЙН САНГААР ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ ИРГЭДИЙН АНТИБИОТИКИЙН ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ, ЭМИЙН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР СУДАЛСАН АСУУМЖИД ХАМРАГДСАН 40 ИРГЭНИЙ МЭДЛЭГ ХАНДЛАГЫГ ТОДРУУЛСАН ДҮН.




3. СҮХБААТАР АЙМГИЙН НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ЭМИЙН САНГИЙН ЭМ ОЛГОЛТ




ЭМИЙН ЖОРЫН МАЯГТ, ЖОР БИЧИЛТ MNS 5376:2016 СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТ

Ерөнхий бүлэг	№	Үзүүлэлт	Нийт эмийн жор	ӨЭМТ (дутагдал)	АНЭ (дутагдал)	АНЭ, ӨЭМТ (дундаж дутагдал)	Шаардлага хангаагүй (%)	Шаардлага хангасан (%)
Эмийн жорын маягт, жор бичилт MNS5376:2016 стандартын хэрэгжилт	1	Жор бичсэн он, сар, өдөр	3058	3	0	3	0.09	99.91
	2	Өвчтөний Овог нэр. нас. Хүйс.	3058	0	0	0	0	100
	3	Өвчний онош бичээгүй	3058	3	49	52	1.7	98.3
	4	Өвчтөний регистрийн дугаар бичээгүй	3058	35	187	222	7.28	92.72
	5	Эмийн нэр. Тун. Хэрэглэх арга тодорхой заах	3058	33	8	41	1.34	98.66
	6	Эмийн нэрийг олон улсын нэршлээр бичээгүй	3058	24	251	275	0.81	99.19
	7	Нэг жоронд 3 ба түүнээс дээш эм бичсэн	3058	3	96	99	3.24	96.76
	8	Жор бичсэн эмчийн гарын үсэг. Гаргац муу	3058	0	50	50	1.63	98.37
	9	Утас бичээгүй	3058	0	360	360	11.8	88.2
	10	Хувийн тэмдэг	3058	24	35	59	1.93	98.07
	11	Эмнэлгийн нэр бичээгүй	3058	0	195	195	6.39	93.61
НИЙТ ЗӨРЧИЛ						1356	36.21	

СУДАЛГААГААР НИЙТ ЖОРЫН МАЯГТАД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ



СУДАЛГААНД ХАМРАГДСАН НИЙТ ЖОРЫН МАЯГТАД НИЙТЛЭГ ИЛЭРЧ БУЙ ДУТАГДАЛ




ДҮГНЭЛТ

1. Судалгаанд хамрагдсан 91 эмчийн эмийн зохистой хэрэглээний мэдлэг, дадал, хандлагыг судлахад эмийн зохистой хэрэглээний талаарх зөвлөгөө, жорын маягтаар хангагдсан, антибиотикийн эмчилгээний стандартыг баримталж хэвшсэн, 224 хэвтэн эмчлүүлэгч эмийг хэрэглэх заавар зөвлөмжийн дагуу уусан, тариаг тарих цаг хугацаанд зориулалтын өрөөнд тарьж, зүүг зориулалтын өрөөнд тавьж хэвшсэн байгааг тогтоов.

Тариаг нэг зүүгээр дараалуулж болон хольж тарьсан, эмийг цаг хугацаанд нь олгоогүй, эмчилгээнд сонгосон эм, тариа дусал, тангийн нэр төрлийг 4 болон 5-аас дээш сонгосон эмчилгээ хийсэн, стационарт хэвтэн эмчлүүлэгч дээр эм, тариа авч ирүүлсэн, буцаан авах талаар мэдээлэл олгоогүй зэрэг нь 31.11 хувийг эзэлж байгаа нь эмч, эмнэлгийн мэргэжилтний эмийн зохистой хэрэглээний мэдлэг дадал хандлага, хууль эрх зүйн мэдлэг дээшлүүлэх, эмчилгээний удирдамжийг тогтмол судалж, мөрдөн ажиллах, иргэдийн эмийн зохистой хэрэглээний мэдлэгийг дээшлүүлэх болон эмийн мэргэжлийн боловсон хүчнийг орон тоогоор ажиллуулах стационарт хэвтэн эмчлүүлэгчдэд эм хэрэглэх заавар, зөвлөгөө өгөх ур чадвар, мэдлэгийн цар хүрээгээ нэмэгдүүлэх шаардлагатай байна.

2. Антибиотикийн жор бичилт, иргэдийн антибиотик эмийн талаарх мэдлэг болон гаж нөлөөний тухай ойлголт, эм зүйчийн эм олголт, зөвлөгөө өгөх чадварын үнэлэмж дунджаар 64.25 судлагдсан нь эм хангамжийн байгууллагууд болон бодлого барьж буй байгууллага иргэдрүү чиглэсэн мэдлэг олгох сургалт мэдээллийг үе шаттай хийж эмийн дасал, гаж нөлөө зохисгүй хэрэглээнээс урьдчилан сэргийлэх, эмийн мэргэжилтнүүд мэдлэг мэргэжлээ байнга дээшлүүлж үзүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч эмийн зохистой хэрэглээг улам сайжруулж, иргэддээ ойртуулах нь зүйтэй байна.

3. Аймгийн төвийн 8 эмийн санд иргэдээс хүлээн авч эмээр үйлчлэн бүртгэж авсан 3058 жорд “Эмийн жорын маягт, жор бичилт” MNS 5376:2016 стандартын хэрэгжилтийн биелэлтийг хянаж үзэхэд 88.22 хувь нь стандартын шаардлага хангаж, 11.78 хувь нь стандартын шаардлага хангаагүй. Судлагдсан нийтлэг дутагдал эмнэлгийн нэр, өвчтөний регистрийн дугаар, эмийн олон улсын нэршил, эмчийн утас бичээгүй дутагдал судлагдсан эмч нарын ажлын хариуцлага хандлагаас шалтгаалж байгаа тул байгууллагууд дотоод хяналтаа тогтмолжуулж шалгуур тавьж хэвшүүлэх нь зүйтэй байна.



Анхаарал тавьсан та
бүхэнд баярлалаа

